

## Гүйцэтгэлийн аудитын хураангуй тайлан

Огноо: 2020.06.25

### Нэг. Ерөнхий мэдээлэл

|                                   |                                                                    |                                      |                                                         |
|-----------------------------------|--------------------------------------------------------------------|--------------------------------------|---------------------------------------------------------|
| Аудитын код:                      | ОРА-2020/06-ГА                                                     | Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр: | Аймгийн ИТХ, ЗДТГ, ОНӨГ,                                |
| Аудитын нэр:                      | “Орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүн” |                                      |                                                         |
| Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр: | Гүйцэтгэлийн аудитын алба                                          | Аудит хийсэн баг, албан тушаалтан:   | Ахлах аудитор<br>В.Жавзмаа,<br>Аудитор<br>Б.Бямбатогтох |

### Хоёр. Аудитын үр дүн:

#### 2.1 Аудитын зорилго, хамарсан хүрээ:

Орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зардлыг үндэслэлтэй, үр нөлөөтэй байхаар төлөвлөсөн эсэх;
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зардлыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж, үнэн зөв тайлагнасан эсэх;

Аудитад аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ, ОНӨГ, төсөл, хөтөлбөрийг гүйцэтгэгч нарын

#### 2.2 Аудитын дүн:

##### 2.2.1 Гол асуулт / аудитын дэд зорилт 1:

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зардлыг үндэслэлтэй, үр нөлөөтэй байхаар төлөвлөсөн эсэх.

##### Хариулт 1:

Орон нутгийн 2019 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад баталсан төсөл, хөтөлбөрүүд нь Орхон аймаг, Эрдэнэт хотын “Ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн зорилт 2025”, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй нийцсэн байна.

Орон нутгийн 2019 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад баталсан төсөл, хөтөлбөр нь төсвийн шууд захирагчдын хүсэлт, холбогдох дүгнэлт, тооцоо судалгаанд үндэслэн боловсруулагдсан байна.

Аймгийн дэд хөтөлбөрүүдийн зорилго зорилт, үр дүн, хугацаа зэргийг тооцон, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан хэдий ч зарим дэд хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнг тоо, чанарын үзүүлэлтээр тодорхойлоогүй нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д “хөтөлбөр” гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг” гэж заасантай нийцэхгүй байна.

Хөрөнгө оруулалтын бус урсгал зардлын шинж чанартай, тухайн байгууллагын урсгал зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой 1,277.3 сая төгрөгийн өртөг бүхий 14 төсөл, хөтөлбөрийг аймгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.

### **2.2.2 Гол асуулт / аудитын дэд зорилт 2:**

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зардлыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж, үнэн зөв тайлагнасан эсэх.

#### **Хариулт 2:**

Төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн 50-80 хувийг урьдчилж олгосон байна. Төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг зориулалтын бус зарцуулсан Орхон аймгийн Засаг даргын 2019 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн А/793 дугаар захирамжаар олгосон сургалтын заалны түрээсийн зардал 1.2 сая төгрөгийг томилолтын зардалд, Орхон аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/259 дугаар захирамжаар Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөс зохион байгуулах үсчин, гоо засалчдын “Алтан хайч 2019” тэмцээний зардалд олгосон санхүүжилтээс 2.0 сая төгрөгийг зориулалтын бусаар бараа материалд зарцуулжээ. Иймд зөрчлийг арилгах албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлээ.

Аймгийн Засаг даргын захирамжаар болон гэрээгээр гүйцэтгүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс, албад хяналт хэрэгжүүлэхээр заасан байна. Анхан шатны баримтын бүрдэл бүрэн хангагдаагүй буюу е баримтгүй, гүйцэтгэлийн тайлангүй, гэрээ дүгнэсэн баримтгүй, бараа материалын зарцуулалтын тайлан, баримтгүй, олгох тооцоог үнэн зөв тооцож олгоогүй 19 төсөл, хөтөлбөрийн 469.9 сая төгрөг, хэрэгжих боломж нөхцөл байдлыг зөв тооцож хянаагүй 1 төсөл, хөтөлбөрт 19.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон зөрчил илэрлээ. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”; Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.19-д “суутган төлөгч” гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д “үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Иймд дээр зөрчлийг давтан гаргахгүй байх, арилгах 2 албан шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.

Төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, санхүүжилтийн байдалд тусгайлан шалгалт хийгээгүй бөгөөд аймгийн ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн байна.

## 2.3 Аудитын гол дүгнэлт

ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫН ДАГУУ ЭРЭМБЭЛЖ, ХООРОНДОО УЯЛДААТАЙ АРГА ХЭМЖЭЭГ ХӨТӨЛБӨРТ ТУСГАЖ САНХҮҮЖҮҮЛСЭН БОЛОВЧ ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ, БАРИМТЫН БҮРДЭЛ БҮРЭН ХАНГАГДААГҮЙ БАЙНА.

## 2.4 Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын нэгтгэл

| № | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн |         | Үүнээс  |               |                 |                                              |
|---|-------------------------------------|-----------------|---------|---------|---------------|-----------------|----------------------------------------------|
|   |                                     | Тоо             | Дүн     | Зөвлөмж | Төлбөрийн акт | Албан шаардлага | Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн |
| А | 1                                   | 2               | 3       | 4       | 5             | 6               | 7                                            |
| 1 | Аймгийн Засаг дарга                 | 4               | 1,277.3 | 4       |               |                 |                                              |
| 2 | Аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэс           | 1               | 473.0   |         |               | 1               |                                              |
| 3 | МСҮТ                                | 1               | 2.0     |         |               | 1               |                                              |
| 4 |                                     |                 |         |         |               |                 |                                              |
|   | ДҮН                                 | 6               | 1,750.3 | 4       | -             | 2               | -                                            |